



ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 12

Улаанбаатар

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2025 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 76 дугаар зүйлийн 76.1.2, 80 дугаар зүйлийн 80.6 дах заалт, Тахько (ХК) компанийн дүрмийн 7.2.16 дах заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоол, Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын 25-ний өдрийн хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид "Хурал" гэх)-ыг 2025 оны 09 дүгээр сарын 05-ний өдрийн 10 цагт тус компанийн байр (Чингэлтэй дүүрэг, 5 хороо, МА-III барилга буюу Анкор төвийн хурлын заал)-нд танхим болон AGM веб суурьтай аппликейшнийг ашиглан цахим /зайнаас/ хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:
 - Компанийн хэлбэрийн өөрчлөлтийг хэлэлцэж батлах.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнээр байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга:	Л.Буянбат	ТУЗ-ийн дарга
Гишүүдэд:	Д.Минжмаа	Гүйцэтгэх захирал
	Э.Чулуунтогтох	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
4. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст шаардлагатай дараах арга хэмжээг авахыг даалгасугай. Үүнд:
 - Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд хүргэх зар мэдээг "Хөрөнгийн бирж" ХК-ийн цахим хуудсаар, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2025 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн дотор нийтэд мэдээлэх;
 - Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд хүргэх зар мэдээг 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэх;
 - Хурлын мэдэгдлийг холбогдох баримт бичгийн хамт Санхүүгийн зохицуулах хороо болон "Хөрөнгийн бирж" ХК-д 2025 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн дотор хүргүүлэх;
 - Хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах тогтоолын төсөл, хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах ажиллагааг үнэт цаасны арилжаа эрхлэх "Таван богд ҮЦК" (ХХ) брокер, дилерийн компанитай гэрээ байгуулж, уг гэрээний дагуу зуучлуулан зохион байгуулах;
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, холбогдох баримт бичгийг санал авах хуудсын хамт үнэт цаасны брокер, дилерийн компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр 2025 оны 08 дугаар сарын 03-ны дотор багтаан хүргүүлэх;
 - Хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах тогтоолын төсөл, хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийг 2025 оны 08 дугаар сарын 04-ны өдрөөс 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийг дуустал 09:30-13:00 цаг, 14:00-17:00 цагт компанийн байрны 315 тоот өрөөнд танилцуулж, саналын хуудсаар санал авах.

5. Хурал зарласны дараа хувьцаа эзэмшигчдэд дор дурдсан баримт бичгийг танилцуулахыг хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст зөвшөөрсүгэй.
 - Компанийн жилийн санхүүгийн тайлан тэнцэл;
 - Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудиторын дүгнэлт;
 - Компанийг өөрчлөн байгуулах тухай төсөл;
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолын төсөл;
 - Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох бусад мэдээлэл.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын “Санал авах хуудас”-ны загварыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
7. Ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрөөр тогтоосугай.
8. Хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн санал авах хуудсыг хүлээж авах сүүлчийн хугацааг 2025 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн 12:00 цагаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Л.Буянбатыг сонгосугай.
10. Хурлын тооллогын комиссын даргаар Э.Уянга, гишүүнээр Г.Ариунжаргал, П.Сансартуяа нарыг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ